

ТАНИЛЦУУЛГА

Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээ байгуулах тухай

Монгол Улсад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр 23 улстай байгуулсан нийт 36 хоёр талт олон улсын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Бүгд Найрамдах Куба Улстай 1989 онд байгуулсан Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг хоёр улсын сүүлийн үеийн эрх зүйн зохицуулалт, практиктай уялдуулж шинэчлэн байгуулахаар хоёр тал 2021 онд тохиролцсон. Ингэхдээ хоёр тал иргэний болон арилжааны хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээд шилжүүлэх, ялтан шилжүүлэх чиглэлээр тус тусад нь гэрээ байгуулах нь зүйтэй гэж үзэж гэрээнүүдийг төслийг боловсруулсан.

Энэ хүрээнд хоёр тал Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг тохироод байна.

Энэхүү гэрээний төсөл нь 20 зүйлтэй бөгөөд төсөлд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээ, туслалцаа үзүүлэх хүсэлт гаргах, биелүүлэх журам, туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэлүүдийг тусгасан.

Энэхүү гэрээг байгуулснаар хоёр улс иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй ажиллагааны хүрээнд шүүхийн баримт бичиг гардуулах, нотлох баримт бүрдүүлэх, шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх гэх зэрэг ажиллагааг нэг нэгнийхээ нутаг дэвсгэр дээр гүйцэтгүүлэх боломжтой болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын дагуу энэхүү гэрээ нь заавал соёрхон батлах олон улсын гэрээ байх тул Олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу уг гэрээг байгуулах асуудал, гэрээнд гарын үсэг зурах шийдвэрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой урьдчилан зөвшилцөнө.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР